



УВС АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

УВС АЙМГИЙН НИЙГЭМ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ  
2017/07

# УВС АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2017/07



[WWW.UVS.NSO.MN](http://WWW.UVS.NSO.MN)

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ХААНААС АВАХ ВЭ?

[www.1212.mn](http://www.1212.mn)



[www.nso.mn](http://www.nso.mn) сайтын  
Хэрэглэгчийн бүртгэлд  
бүртгүүлснээр цахим  
хаягаар тогтмол  
авч болно.



Monstat ezStat  
аппликейшн



**1900-1212**



Лавлах утас

@statistic\_mn



Статистик  
мэдээлэл



Үндэсний Статистикийн  
Хорооны  
НОМЫН САН



Онлайн лавлах  
мессенжер  
8:30-17:30

**УВС АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**УВС АЙМГИЙН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**7 сар  
2017**

**Улаангом хот**

**ГАРЧИГ**

Ерөнхий тэмдэглэл .....4

Статистик мэдээллийн өнгө, таних тэмдэг .....5

Хэрэглэгчдэд лавлагаа .....7

Товч танилцуулга.....8

Үндсэн үзүүлэлтүүд .....38

IV.Хөдөлмөр .....40

VI. Нийгмийн даатгал, халамж .....45

VIII. Эрүүл мэнд .....48

XI. Байгаль орчин .....51

XII. Гэмт хэрэг .....52

XIV.Мөнгө, зээл .....54

XV. Орон нутгийн төсөв .....55

XVI.Гадаад худалдаа.....58

XVII. Үнэ .....59

XVIII. Хөдөө аж ахуй .....60

XIX. Үйлдвэр .....61

**ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :**

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. ( I, II, III , IV, V..... г.м )  
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.
  2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :
    - ... мэдээлэл байхгүй
    - 0.0 маш бага тоо
    - гүйцэтгэл байхгүй
- Д - дахин
3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

Үндэсний статистикийн хорооны даргын  
2013 оны 12 сарын 06 өдрийн 1115/Т тоот  
тушаалын гуравдугаар хавсралт

### СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ӨНГӨ, ТАНИХ ТЭМДЭГ

Д/д	Таних тэмдэг	Мэдээллийн нэр	Өнгө	Вэбийн өнгө R/G/B	Хэвлэлийн өнгө S/M/Y/K
1		Засаг захиргаа, нутаг дэвсгэр	Шар	255/212/0	0/15/100/0
2		Сонгууль	Шар	255/212/0	0/15/100/0
3		Хүн ам	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
4		Хөдөлмөр	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
5		Хүн амын амьжиргаа	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
6		Нийгмийн даатгал, халамж	Улаан	217/31/61	10/100/80/0
7		Боловсрол, шинжлэх ухаан	Шар	255/212/0	0/15/100/0
8		Эрүүл мэнд	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
9		Хүний хөгжил	Улаан	217/31/61	10/100/80/0
10		Соёл, аялал жуулчлал, биеийн тамир, спорт	Шар	255/212/0	0/15/100/0
11		Байгаль орчин	Ногоон	14/178/76	80/0/100/0
12		Гэмт хэрэг	Улаан	217/31/61	10/100/80/0

Нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга

Д/д	Таних тэмдэг	Мэдээллийн нэр	Өнгө	Вэб-д R/G/B	Хэвлэлд S/M/Y/K
13		Үндэсний тооцоо	Хөх	23/71/158	100/85/0/0
14		Мөнгө, банк, даатгал	Хөх	23/71/158	100/85/0/0
15		Төрийн санхүү	Хөх	23/71/158	100/85/0/0
16		Төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа	Хөх	23/71/158	100/85/0/0
17		Үнэ	Хөх	23/71/158	100/85/0/0
18		Хөдөө аж ахуй	Улбар шар	248/165/26	0/40/100/0
19		Аж үйлдвэр	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
20		Тээвэр, харилцаа, холбоо	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
21		Худалдаа, үйлчилгээ	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
22		Барилга, орон сууц, нийтийн аж ахуй	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
23		Бизнес регистр	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
24		Дэлхийн улс орнуудын хөгжил	Хөх цэнхэр	64/133/197	75/40/0/0

## Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа:

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргаж буй дараахь мэдээлэл, танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүнг [uvs.nso.mn](http://uvs.nso.mn) хаягаар орох болон аймгийн Засаг даргын Тамгын газрын II байранд байрлуулсан электрон самбарыг ашиглан үзэж, холбогдох мэдээллээ авч болно. Үүнд :

- ✚ Аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулгууд
- ✚ Ажиллах хүчний үр дүнгийн танилцуулга
- ✚ Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны үр дүн
- ✚ 2010 оны Хүн ам орон сууцны тооллогын үр дүн, сум, багаар
- ✚ Аж ахуйн нэгжийн тооллогын үр дүн, аймгуудаар, сумдаар, 2010 он
- ✚ 2013 оны ХАА-н салбарын танилцуулга,
- ✚ 2013 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- ✚ 2013 оны Аймгийн үйлдвэр, үйлчилгээний салбарын танилцуулга
- ✚ 2014 оны ХАА-н салбарын танилцуулга
- ✚ 2014 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- ✚ 2014 оны Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга
- ✚ 2014 оны ажил эрхлэлтийн байдлын танилцуулга
- ✚ Аймгийн ДНБ үйлдвэрлэлт-2014 онд
- ✚ 2015 оны ХАА-н салбарын танилцуулга
- ✚ 2015 оны Хүн амын танилцуулга
- ✚ 2015 оны Аж үйлдвэр, үйлчилгээний салбарын танилцуулга
- ✚ 2015 оны Хүн амын ажил эрхлэлтийн танилцуулга
- ✚ 2015 оны Статистикийн эмхэтгэл
- ✚ 2016 оны ХАА-н салбарын танилцуулга
- ✚ 2016 оны Аймгийн хүн амын төлөв байдлын танилцуулга
- ✚ 2016 оны Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга
- ✚ 2016 оны Хүн амын хөтөлмөр эрхлэлтийн байдлын танилцуулга
- ✚ 2016 оны Статистикийн эмхэтгэл


Улс, аймгийн мэдээлэл авах хаяг: [uvs.nso.mn](http://uvs.nso.mn)      [www.uvs.gov.mn](http://www.uvs.gov.mn)

Мэдээллийн сангаас авах бол: [www.1212.mn](http://www.1212.mn)

Увс аймгийн Статистикийн хэлтсийн ажилтнуудтай харилцах хаяг :

[uvs@nso.mn](mailto:uvs@nso.mn)/ албаны хаяг /

Утас: 70452322, 80992322, 98802322, 90886088, 95760155,  
99458459, 99760175, 99673065, 88456262






### III. ХҮН АМ

Аймгийн хэмжээнд 2017 оны эхний 7 сард 1214 эх амаржиж, 1218 хүүхэд төрж, мөн нас баралт 256 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 30 (2.5%) -ээр, төрсөн хүүхэд 27 (2.2%)-аар нэмэгдэж, нас баралт 29 (10.2 %) -аар өмнөх оны мөн үеэс буурчээ. 1000 хүнд ноогдох төрөлт 15.1, нас баралт 3.2, цэвэр өсөлт 11.9 болов. Өмнөх оны мөн үеэс 1000 хүнд ноогдох төрөлт 0.2, нас баралт 0.5 хувиар буурч, цэвэр өсөлт 0.3 пунктээр тус тус өсчээ.

Зураг III.1 1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



1000 хүн амд ноогдох төрөлтийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 0.4 пунктээр, нас баралтын тоо 0.3 пунктээр буурсан байна.

Гэрийн төрөлт 7 гарч, өмнөх оны мөн үеэс 1 төрөлтөөр цөөн байна. Нийт нас баралтын 16.0 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр буурсан байна.

#### АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

1000 хүнд ногдох төрөлт: Төрсөн хүүхдийн тоог хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

1000 хүнд ногдох нас баралт: Нас барсан хүний тоог хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

Ердийн цэвэр өсөлт: 1000 хүнд ногдох төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.




### IV ХӨДӨЛМӨР

#### 4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 940 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 22.0 хувиар буюу 265 хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 439 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 46.7 хувийг эзэлж байна.

2017 оны 7 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 11.6 хувиар буюу 123 ажилгүйчүүдээр буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 1.2 хувь нь буюу 11 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.


Зураг 4.1 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сүүлийн 5 жилээр



Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт энэ оны эхний 7 сарын байдлаар 1768 ажилгүй иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан ажилгүйчүүдээс 380 иргэн ажилд зуучлагдан орж, 1950 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ.


Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 26.8 хувь нь 15-24 насны, 35.4 хувь нь 25-34 насны, 20.4 хувь нь 35-44 насны, 14.6 хувь нь 45-54 насны, 2.7 хувь нь 55-59 насны, 0.1 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна. Ажилгүйчүүдийн 29.0 хувь нь дээд, 10.0 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 46.2 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 14.8 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс байна.

Зураг 4.2 Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролын түвшингээр



2017 оны 7 сарын байдлаар 548 ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувиар буурчээ.

Зураг 4.3 Ажлын байрны захиалга, ажилд орсон хүний тоо




Ажлын байрны захиалга эдийн засгийн ангиллаар авч үзэхэд 1.8 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 31.9 хувийг удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 8.8 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар, 5.8 хувийг боловсролын салбар, 1.1 хувийг хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 0.4 хувийг урлаг үзвэр, тоглоом, 46.9 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар, 2.8 хувийг барилга, 0.6 хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар эзэлж байна.

Зураг 4.4 Ажлын байрны захиалга, салбараар, бүтцээр




Ажлын байрны захиалгыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 6.7 дахин, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа албан журмын нийгмийн хамгаалал 2.0 дахин тус тус өсч бусад үйл ажиллагааны салбарууд 2.7 – 86.3 хувиар тус тус буурсан байна.

Зураг 4.5 Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллаар




Шинэ ажлын байранд орсон хүмүүсийн 3.8 хувь нь менежер, 31.3 хувь нь мэргэжилтэн, 19.0 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын ажилтан, 2.8 хувь нь машин механизмын операторч, угсрагчийн ажилд, 7.3 хувь нь техникч болон дэд мэргэжилтэн, 6.3 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан, 0.9 хувь нь контор үйлчилгээний ажилтан, 8.2 хувь нь ХАА,ойн ажилтан, 0.9 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжил, 19.3 хувь нь энгийн ажил, мэргэжилд ажилд орсон байна.

Зураг 4.6 Ажлын шинэ байранд ажилд орсон хүмүүс, ажил мэргэжлийн ангиллаар, бүтцээр



Шинэ ажлын байранд орсон иргэдийн 11.1 хувь нь боловсролын салбарт, 6.6 хувь нь зочид буудал, байр, сууц, болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт, 13.0 хувийг боловсруулах үйлдвэрлэл салбар, 17.4 хувь нь худалдааны салбар, 14.2 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт, 10.1 хувь нь барилгад, 4.7 хувь нь мэдээлэл холбооны салбар, 0.6 хувь нь тээвэр холбооны салбар, 0.6 хувь нь усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбар, 3.5 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар, 0.9 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар, 6.0 хувь нь үйлчилгээний бусад салбарт тус тус ажилд оржээ.

Зураг 4.7 Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо, салбараар



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### Бүртгэлтэй ажилгүй иргэн

Бүртгэлтэй ажилгүй иргэд: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.




## VI НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 7 сард 8.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 136.4 (1.6%) сая төгрөгөөр өсч, сангийн зарлага 24.4 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 550.3 (2.2%) сая төгрөгөөр өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 136.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 91.7 (4.0%), ҮОМШӨ - ын даатгалын сангийн орлого 5.9 (1.3%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 1921.6 сая төгрөгөөр буурахад тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 334.0 (25.1%) сая төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлжээ.


Зураг 6.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, эхний 7 сард, сая төгрөг



Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөө Улаангом суманд 8.8, Бөхмөрөн суманд 6.2 хувиар тасарч, бусад сумдад 3.0 – 20.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сан 776.7 сая төгрөгийн авлагатай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 168.6 (27.7%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 38.8 хувийг төсөвт байгууллагын өглөг эзэлж байна.


Зураг 6.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, сангуудаар, сая төгрөг



Сангуудаар авч үзвэл өмнөх оны мөн үеэс тэтгэмжийн даатгалын сангийн орлого 2.3 (0.4%), тэтгэврийн даатгалын сангийн орлого 38.3 (0.7%), эрүүл мэндийн даатгалын сангийн орлого


91.7 (4.0%), ҮОМШӨ –ний даатгалын сангийн орлого 5.9 (1.3%) сая төгрөгөөр өсч, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 1.9 (1.5%) сая төгрөгөөс буурсан байна.

Зураг 6.3 Нийгмийн даатгалын сангийн зарлага, сангуудаар, сая төгрөг




Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 211.5 (136.6%), эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 127.4 (6.4%) сая төгрөгөөр тус тус өсч, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 334.0 (25.1%), үйлдвэрийн осол мэргэжлээс шатгаалах өвчний даатгалын сангийн зарлага 4.9 (8.3%), тэтгэвэрийн даатгалын сангийн зарлага 550.3 (2.6%), сая төгрөгөөр буурсан байна.

Зураг 6.4 Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Нийгмийн халамжийн сангаас энэ оны эхний 7 сард 30.2 мянган хүнд 5965.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс 412.3 (7.4%) сая төгрөгөөр өсч, орон нутгийн нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчид 96 (0.3%) хүнээр буурсан байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт энэ оны эхний 7 сард 1.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 115 (6.2%) хүнээр буурсан бол олгосон тэтгэвэр 107.0 (6.9%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг 6.5 Халамжийн сангийн зарцуулалт, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөг



Асрамжийн газар нийт 15 хүн асруулж байгаа бөгөөд 10 эмэгтэй байна. Асрамжийн үйл ажиллагаанд нийт 89.2 сая төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 12.1 (11.9%) сая төгрөгөөр, асруулагчийн тоо 5 хүнээр тус тус буурсан байна.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Даатгуулагч: Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг ойлгоно.

Нийгмийн даатгал: Иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын төрлүүд: Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан: Энэ нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн халамж: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл /-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.


Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.



### VIII. ЭРҮҮЛ МЭНД


Энэ оны 7 дугаар сард 218 хүүхэд мэндэлж, өмнөх сараас төрөлтийн тоо 30 (15.6%) - аар өссөн байна.

Зураг 8.1 Амьд төрөлт, сараар, хүүхдийн тоогоор




Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл эхний 7 сард 20 болж, өмнөх оны мөн үеэс 16 (44.5%) - аар, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 25 болж, өмнөх оны мөн үеэс 15 (37.5%) - аар буурсан байна. Нялхсын эндэгдэл энэ оны 7 дугаар сард 5 болж, өмнөх сараас 1 хүүхдээр нэмэгдсэн байна.

Зураг 8.2 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл, сараар



Нялхсын эндэгдлийн түвшин өмнөх 4 жилийн дунджаас 5.5 промилээр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 5.5 промилээр тус тус буурсан байна.

Зураг 8.3 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын ба 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл



1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл Малчин 750.0, Цагаанхайрхан 500.0, Наранбулаг 166.7, Зүүнхангай 111.1, Хяргас 100.0, Улаангом суманд 10.4 гарч аймгийн дундаж 16.4 байна.

Зураг 8.4 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын

эндэгдлийн түвшин, сумаар




Зураг 8.5 1000 амьд төрөлтөд ноогдох 5 хүртэлх

насны хүүхдийн эндэгдлийн түвшин, сумаар




Энэ оны эхний 7 сард осол гэмтлийн улмаас 25 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 611 болсон нь өмнөх оны мөн үеэс өвчлөгчдийн тоо 145 (31.1%) - аар өсч, нас баралтын тоо 3 (10.7%) - аар буурсан байна. Өмнөх 4 жилийн дунджаас өвчлөгчдийн тоо 19.7 хувиар өсч, осол гэмтлийн нас баралтын тоо 19.4 хувиар буурсан байна.

Зураг 8.6 Осол гэмтлийн өвчлөл, нас баралтын тоо




Хорт хавдрын өвчлөл 53 гарч өмнөх оны мөн үеэс 22 (29.3%) - аар, нас баралт 88 гарсан нь өмнөх оны мөн үеэс 1 (1.1%) - аар буурчээ. Хорт хавдрын улмаас нас барагчдын тоо өмнөх 4 жилийн дунджаас 5.7 хувиар өсч, өвчлөгчдийн тоо 38.7 хувиар буурсан байна.

Зураг 8.7 Хорт хавдрын өвчлөл, нас баралтын тоо




Эхний 7 сард халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 370 болж өнгөрсөн оны мөн үеэс 167 (31.1%) буурч, өмнөх 4 жилийн мөн үеийн дунджаас 2.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 8.8 Халдварт өвчний гаралт, тоогоор




Энэ оны 7 дугаар сард халдвар өвчний 38 тохиолдол гарч, өмнөх сараас 1 (2.5%) - өөр цөөн гарсан байна.

Зураг 8.9 Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, сараар



Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл БЗХӨ нийт халдварт өвчний 56.5, салхинцэцэг өвчин 20.3, сүрьеэ 9.7, цусан суулга 2.7, гепатит 2.4, бусад өвчнүүд 8.4 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс БЗХӨ - ний эзлэх хувь 40.5, сүрьеэ 3.4, гепатит 0.8 пунктээр тус тус өсч, өмнөх онд гарч байсан улаанбурхан өвчний тохиолдол энэ онд гараагүй байна.

Зураг 8.10 Хүн амд зонхилон тохиолдох халдварт




Зураг 8.11 Хүн амд зонхилон тохиолдох халдварт




10000 хүн тутмаас 45.4 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Малчин 286.3, Улаангом 63.2 Түргэн 61.3, Хяргас 51.7, байгаа нь аймгийн дунджаас 6.2 – 240.8 процентимилээр өндөр, бусад сумдад аймгийн дунджаас 3.5 – 41.8 процентимилээр бага байна.

Зураг 8.12 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Зураг 8.13 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Амбулаториор 233.1 мянган хүнд үзлэг хийгдэж, 13.2 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүн 21.8 мянган хүн (10.3%) - аар, хэвтэн эмчлүүлэгчид 0.5 мянган хүн (3.8%) - оор тус тус өссөн байна.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### ЭРҮҮЛ МЭНД

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байгааг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нялхсын эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин: Тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны дундаж хүн амын тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндэснийг хамруулна. хөрөнгийг ойлгоно.



## ХИ. БАЙГАЛЬ ОРЧИН

### 11.1 Цаг уурын байдал

Энэ оны 7 - р сард агаарын температур дунджаар Баруунтуруун, Давст, Завхан, Зүүнговь, Наранбулаг, Сагил, Түргэн, Тэс, Ховд, Хяргас, Өлгий, Зүүнхангай, Улаангом сумдад нэмэх 20-оос илүү дулаарч бусад сумдад нэмэх 20 градус хүртэл дулаарсан байна. Хөрсний гадаргын дундаж температур Баруунтуруун, Зүүнхангай, Малчин, Өмнөговь, Өндөрхангай, Цагаанхайрхан, Тэс, Түргэн, Улаангом сумдад нэмэх 30 хүртэл дулаарч бусад сумдад нэмэх 30 –аас илүү дулаан байсан байна. Хөрсний гадаргын температур хамгийн ихдээ Давстад 65.5 хэм, хамгийн багадаа Өндөрхангайд 1.3 хэм дулаан байсан байна. Салхины хамгийн их хурд Завхан, Өмнөговь, сумдад 21-24 м/сек хүрсэн бөгөөд 10 м/сек-ээс их салхитай өдөр Өмнөговь, Завхан сумдад 27 өдөр байв.

Өндөрхангайд 25.1, Цагаанхайрханд 26.6, Малчинд 27.4, Баруунтуруунд 35.2, Тэсд 38.7 мм хур тунадас орсон нь бусдаас илүү байна. Хур тунадастай өдөр хамгийн олон нь Баруунтуруунд 12, Малчинд 16, Өндөрхангайд 15, Улаангом 16, Тэсд 14 өдөр байлаа.

Агаарын чанарын мэдээгээр хүлцэх агууламжаас давсан тохиолдол гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс тоос 0.007 мг/м<sup>3</sup>, нүүрстөрөгчийн дутуу исэл 0.28 мг/м<sup>3</sup> - аар тус тус бага байлаа.

### 11.2 Аюулт үзэгдэл, ослын мэдээ

2017 оны 7 дугаар сард гол мөрөн, нуур усанд осолдсон золгүй тохиолдол 1, хүчтэй салхи шуурганы аюулт үзэгдэл 1, аврах ажиллагааны дуудлага 1, объектын гал түймэр 13, мал амьтаны гоц халдварт өвчний тохиолдол 1, ой хээрийн түймэр 1 гарч шуурхай арга хэмжээ авсан байна.

Дээрх 18 удаагийн гамшиг болон осол гал түймрийн улмаас төр болон иргэдийн хувийн өмчинд 88.0 сая төгрөгийн хохирол учирч, 2 хүүхдийн амь нас эрсдэж, гамшиг осол, гал түймрийн аюулаас 89.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалжээ.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### БАЙГАЛЬ ОРЧИН

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.


Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



## ХИИ. ГЭМТ ХЭРЭГ

Энэ оны эхний 7 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 188 болж өнгөрсөн оны мөн үеэс 12.6 хувиар өссөн бол өмнөх 4 жилийн дунджаас 4 гэмт хэргээр буюу 2.1 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 96 хүн гэмтэж, 184 иргэн хохирсон байна.

Зураг 12.1 Гэмт хэргийн гаралт, жил бүрийн эхний 7 сард, тоо




Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 21.9 үүнээс бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг 5.7, өмчлөх эрхийн эсрэг

гэмт хэрэг 10.6 хувиар тус тус өссөн бол танхайрах гэмт хэрэг 60.0, залилан 75, иргэдийн өмчийн хулгай 20 хувиар тус тус буурсан байна.

Хулгайн гэмт хэргээс малын хулгайн гэмт хэрэг 2.2 дахин өсч, тээврийн хэрэгслийн хулгай 2 гарч, халаасны хулгайн гэмт хэрэг гараагүй байна.

Зураг 12.2 Гэмт хэргийн гаралт, төрлөөр, тоо




Энэ оны эхний 7 сард тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 10.0, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 80 хувиар тус тус буурсан ба иргэдийн улс төрийн болон бусад эрх чөлөөний эсрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд гараагүй байна.

Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар нь авч үзвэл эмэгтэй хүн оролцсон 12, согтуугаар үйлдэгдсэн 65, гэр бүлийн хүчирхийллийн улмаас гарсан гэмт хэрэг 15, бүлэглэн 7, гудамж талбайд 22, гэр орон сууцанд 69 гэмт хэрэг гарсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн 188 хүнээс 6.4 хувь буюу 12 нь эмэгтэйчүүд, 3.2 хувь буюу 6 нь хүүхэд байна.

Өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн тоо 12.6 хувиар өсчээ.

Гэмт хэргийн улмаас 257.2 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18.6 хувиар өссөн байна. Иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 213.3 сая төгрөг буюу 82.9 хувийг нөхөн төлүүлжээ. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед 224.7 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна.




Нийт гэмт хэргийн дийлэнх нь Улаангом суманд үйлдэгдсэн бөгөөд нийт 84 тохиолдол гарснаас бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэргийн 41, бусдын эд хөрөнгө хулгайлах 20 тохиолдол гарч өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн гаралт 2.3 хувиар буурсан байна.


Аймгийн хэмжээнд нийт 5549 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 18.3 хувиар өссөн байна. Энэ оны эхний 7 сарын байдлаар 159 хүн тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, торгуулан, 497 хүн саатуулагджээ.

Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 82 хүнд холбогдох 58 хэргийг хянан шийдвэрлэжээ. Ял шийтгүүлэгчдийн дийлэнх буюу 43.9 нь бусдын эд хөрөнгийг хулгайлах, 17.1 нь бусдын бие мах бодид хөнгөн гэмтэл санаатай учруулах зүйл ангиар шийтгүүлсэн байна.

Зураг 12.3 Таслуулсан гэмт хэрэг, шийтгүүлсэн хүний тоо, эхний 7 сард, тоо



Зураг 12.4 Ял шийтгүүлэгчид насны бүлгээр



Ял шийтгүүлэгчдийн 3.7 хувь нь 16 хүртэл насны, 28.0 хувь нь 36-60 насны, 68.3 хувь нь 17-35 насны хүмүүс байна.

## ГЭМТ ХЭРЭГ

Гэмт хэрэг: Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18, түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

Гэмт хэргийн хохирогч: Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг ойлгоно /МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 42.1 дэх заалт/.

Учирсан хохирол: Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхэд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Нөхөн төлбөр: Хохирлын нөхөн төлүүлэлт нь хүний эрх, эрх чөлөөний хир хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө нь байсан хэмжээнд сэргээн бүрдүүлэхийг ойлгоно.

Сэжигтэн: МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 35.1-д заасны дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан; гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан; уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон; уг этгээд хэргээ илчлэн ирсэн; гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

Яллагдагч: МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 36.1-д заасны дагуу энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг ойлгоно.



## XIV. МӨНГӨ, БАНК, ДААТГАЛ

Монгол банкны эх үүсвэрээр 26.3 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 303.7 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 345.4 тэрбум төгрөгийг буюу гаргасан мөнгөний 113.7 хувийг эргүүлэн татсан байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 8.5 сая төгрөгөөр буюу 47.7 хувиар, гүйлгээнд гаргасан мөнгө 61.0 тэрбум төгрөг буюу 25.1 хувиар тус тус өссөн бол гүйлгээнээс татсан мөнгө 5.0 тэрбум төгрөгөөр буюу 21.7 хувиар буурсан байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 165.4 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 6.7 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 5.3 тэрбум төгрөгөөр буюу 3.3 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 0.8 тэрбум төгрөгөөр буюу 12.8 хувиар тус тус өссөн байна.

4.0 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.4 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 1.6 тэрбум төгрөгөөр буюу 71.4 хувиар өссөн байна.


Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 7.8 тэрбум төгрөгөөр буюу 5.0 хувиар өссөн байна.

Зураг 14.1 Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, сая төгрөг



Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 87.1 тэрбум төгрөг болсон байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 17.4 хувиар буюу 12.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Сүүлийн 4 жилийн дунджаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 26.5 тэрбум төгрөгөөр буюу 43.8 хувиар өссөн байна.

Зураг 14.2 Хадгаламжийн үлдэгдэл, сая төгрөг



Арилжааны банкууд иргэд, аж ахуй нэгж нийт 44.3 мянган зээлдэгчдэд 91.4 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд төрлөөр нь авч үзвэл лизингийн зээл 1.9 хувь, хадгаламж барьцаалсан зээл 13.2 хувь, малчны зээл 17.1 хувь, бизнесийн зээл 17.1 хувь, орон сууц, хашаа байшингийн зээл 4.2 хувь, цалингийн зээл 27.3 хувь, тэтгэврийн зээл 14.5 хувийг тус тус эзэлж байна. Нийт олгосон зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зээлдэгчдийн тоо 0.3 хувиар, зээлийн хэмжээ 5.3 хувиар тус тус өссөн байна. Төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 14.04, төгрөгийн зээлийн дундаж хүү 18.95 хувьтай байгаа бол 1 ам.доллартай харьцах ханш 2419.42 төгрөг байна.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### МӨНГӨ ЗЭЭЛ

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Төгрөг болон валютын хадгаламж: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.



## XV ТӨРИЙН САНХҮҮ

### 15.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО


Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор 2017 оны эхний 7 сард аймгийн төсөвт 11.2 тэрбум төгрөг оруулахаас 11.5 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 102.4 хувьтай, 263.8 сая төгрөгөөр давж биелэгдлээ. Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 5.5 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 5.8 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 104.8 хувиар биелүүлж 4.8 хувиар буюу 266.0 сая төгрөгөөр давуулан биелүүллээ.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 1.3 тэрбум төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 1.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 100.1 хувиар биелүүлж 0.1 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр давуулан биелүүллээ. Аймгийн төсөвт өөрийн орлогоор 4.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 4.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 106.2 хувиар биелүүлж 6.2 хувиар буюу 264.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 5.5 хувиар буюу 298.3 сая төгрөгөөр их, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлсэн орлого 13.9 хувиар буюу 154.1 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 3.3 хувиар буюу 144.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.


2017 оны эхний 7 сард улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас нэмэгдсэн өртөгийн татвар 0.8 хувиар, онцгой албан татвар 40.6 хувиар, тус тус давж биелэгдэж, агаарын бохирдлын төлбөр 21.8 хувиар ААНБ-ын орлогын албан татварын төлөвлөгөө 19.4 хувиар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 11.8 хувиар тус тус тасарсан байна.

Зураг 15.1 Төсвийн орлогын бүтэц, хувиар




Аймгийн өөрөө бүрдүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 5.5 хувиар, өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 11.0 хувиар өссөн байна.

Зураг 15.2 Төсвийн орлогын өсөлт бууралт, онуудаар, сая төгрөг



Аймгийн төсвийн нийт зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь 14.7 хувь болж өмнөх 3 жилийн дундаас 0.7 пунктээр буурсан байна.

Зураг 15.3 Аймгийн төсвийн зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь




### 15.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 39.3 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 12.8 хувиар, өмнөх 3 жилийн дунджаас 15.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 15.4 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөг



Зураг 15.5 Төсвийн зарлагын бүтэц, хувь



Төсвийн зардлын 30.0 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 52.9 хувийг боловсрол соёлын үйл ажиллагаанд, 6.9 хувийг эрүүл мэнд, амралт, спортын үйл ажиллагаанд, 0.3 хувийг барилга хот байгуулалтанд, 0.2 хувийг хүн амын хөгжил нийгмийн хамгаалалын үйл ажиллагаанд зориулан зарцуулсан байна.


### 15.3 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр 2017 оны эхний 7 сард 531.7 сая төгрөгийн өртэй, 90.6 сая төгрөгийн авлагатай гарч, өмнөх оны мөн үеэс өглөг 44.2 хувиар буурч, авлага 19.4 хувиар өссөн байна.

Төсөвт байгууллагын өглөг өмнөх 3 жилийн дунджаас 11.2 хувиар өссөн байна.


Зураг 15.6 Төсөвт байгууллагуудын өглөг,

сая.төгрөг



Зураг 15.7 Төсөвт байгууллагуудын авлага

сая.төгрөг



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого зарлагын тооцоог Олон улсын Валютын сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсвийн орлого, үүнээс улсын төсөвт /аймгийн/ төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа. Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсвийг хэлнэ.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл;


Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



#### XVI. ГАДААД ХУДАЛДАА

Энэ оны 7 сарын байдлаар импорт 11738.8 мян.ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 3777.9 мян.ам.доллараар буюу 24.3 хувиар буурсан байна. Гол нэрээс 13.4 мян.тн нефть бүтээгдэхүүн, 766.0 тн хивэг, 457.7 тн овъёос, хөц будаа 67.0 тн, тахианы өндөг 572.4 мянган ширхэг, ачааны автомашин,чиргүүл 3 ширхэг, жимс жимсгэнэ 13.1 тн, хүнсний ногоо 3.1 тн, мебель тавилга 100 ширхэг, зоргодсон хавтан 794.1 м2, ургамлын тос 0.2 тонныг тус тус импортоор оруулсан байна.

Зураг 16.1 Нийт импорт, экспорт жил бүрийн эхний 7 сараар мян.ам.доллар



Өнгөрсөн оны мөн үеэс тахианы өндөгний импортын хэмжээ өсч, бусад бараа бүтээгдэхүүний импорт 16.0-96.1 хувиар буурсан байна.

Энэ оны эхний 7 сарын байдлаар 45.5 мян.ам.долларын бараа бүтээгдэхүүнийг экспортолсон ба экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 4.4 дахин нэмэгдсэн байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ГАДААД ХУДАЛДАА

Импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана. Реимпорт- Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно. Реэкспорт- өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.



**XVII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС**

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 238 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 7-р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны мөн үеэс 1.4 , оны эхнээс 2.9 , өмнөх сараас 0.1 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 17.1 Хэрэглээний барааны үнэ тарифын 7-р сарын индекс, хувь

Бүлэг	2017 VII	2017 VII	2017 VII
	2016 VII	2016 XII	2017 VI
<b>ЕРӨНХИЙ ИНДЕКС</b>	<b>101.4</b>	<b>102.9</b>	<b>100.1</b>
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	97.2	105.5	99.0
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	104.1	101.6	99.8
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	101.2	99.4	100.0
04. ОРОН СУУЦ УС,ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	102.3	93.2	100.0
05. ГЭРАХУЙН ТАВИЛГА, ГЭРАХУЙН БАРАА	101.6	101.3	100.1
06. ЭМ ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	111.6	108.8	100.2
07. ТЭЭВЭР	107.3	112.1	102.9
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
09. АМРАЛТ,ЧӨЛӨӨТ ЦАГ,СОЁЛЫН БАРАА,ҮЙЛЧИЛГЭЭ	101.5	101.5	100.0
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТ.БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	105.1	102.7	100.0


Өмнөх сараасаа гэр ахуйн тавилга,гэр ахуйн барааны үнэ 0.1,эм тариа эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.2, тээврийн бүлгийн үнэ 2.9 хувиар өсч, согтууруулах ундаа

тамхины бүлгийн үнэ 0.2, хүнсний барааны бүлгийн үнэ 1 хувиар буурч бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.

Зураг 17.1 Хэрэглээний үнийн индекс 7 сар, бүлгээр, хувь




Зураг 17.2 Сүүлийн 5 жилийн индексийг өмнөх сар, оны эхтэй харьцуулсан индекс



Сүүлийн 5 жилийн 7-р сарыг: - оны эхтэй харьцуулсан индексээс харахад 2014 оны 7-р сард хамгийн өндөр буюу 9.8, өмнөх сартай харьцуулсан индексээс харахад 2016 оны 7 сард хамгийн өндөр буюу 0.9 хувийн өсөлттэйгээр тооцогдож байна.

Зураг 17.3 Сарын инфляцийн түвшин




Өргөн хэрэглээний 11 бараа, бүтээгдхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр цуглуулж өөрчлөлтийг судалж байна. 2017 оны 7-р сард Улаангом хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх 6 дугаар сарын дундаж үнэтэй харьцуулахад 6.2 хувь буурсан байна. Өмнөх сарын дундаж үнээс хонины мах 6.1, үхрийн мах 6.4, ямааны мах 14.3, сүү 16.1 хувиар буурчээ.

Махны дундаж үнэ:


Хонь, үхрийн махны дундаж үнэ сарын турш тогтвортой байлаа. Ямааны махны дундаж үнэ 3 дахь долоо хоногоос 500 төгрөгөөр буурч сарын сүүлч хүртэл тогтвортой байлаа.

Зураг 17.4 Махны үнэ, долоо хоногоор, төрлөөр




7-р сард дунджаар 1 кг хонины мах 5500, үхрийн мах 5500, ямааны мах 3750, 1 л шингэн сүү 783, элсэн чихэр 2350, цагаан будаа 2417 төгрөгийн үнэтэй байсан байна.

■ 2016-VII сарын дундаж үнэ, төг ■ 2017-VII сарын дундаж үнэ, төг




■ 2016-VII сарын дундаж үнэ, төг ■ 2017-VII сарын дундаж үнэ, төг



Бензин, шатахууны дундаж үнэ өнгөрсөн оны мөн үеэс 100 төгрөгөөр өссөн байна.

■ 2016-VII сарын дундаж үнэ, төг ■ 2017-VII сарын дундаж үнэ, төг



#### АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

##### ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2015 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 238 нэр төрөл болгож 2015 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

Инфляци: Үнэ өсч тэр хэмжээгээр мөнгөний ханш буурахыг хэлнэ. Инфляцийн түвшинг тооцоходоо дараах томъёог ашиглана. Үүнд:

$$\text{Инфляцийн түвшин} = \frac{I_t - I_0}{I_0} * 100$$

$I_t$  – Тайлант үеийн үнийн индекс  
 $I_0$  – Суурь үеийн үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жинг хэлнэ.

Хэрэглээний сагс: Дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, Ласпейресийн үнийн индексийн томъёогоор тооцож байна. Үүнд:

$$I_p^t = \frac{\sum_{i=1}^n (p_i^t * q_i^0)}{\sum_{i=1}^n (p_i^0 * q_i^0)}$$

$I_p^t$  – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс  
t – Тайлант үе  
0 – Суурь үе  
 $p_i^t$  – i барааны тайлант үеийн үнэ  
 $p_i^0$  – i барааны суурь үеийн үнэ  
 $q_i^0$  – i барааны суурь үеийн худалдан авсан тоо



## XVIII. ХӨДӨӨ АЖ АХУЙ

### 18.1 ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Малын үнэ: 2017 оны 7 дугаар сард буурны 1450.0, атны үнэ 790.0, ингэний үнэ 900.0, бүх насны адууны үнэ 70.0 – 1150.0, бүх насны үхрийн үнэ 100.0 – 1150.0, бүх насны хонины үнэ 30.0 -130.0, бүх насны ямааны үнэ 20.0 – 95.0 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.


Өмнөх сартай харьцуулахад атан тэмээний үнэ 235.0, үнээний үнэ 32.1, эм ямааны үнэ 5.1, ухна ямааны үнэ 5.0, эр хонины үнэ 3.3, эр ямааны үнэ 3.2 төгрөгөөр буурч, буурны үнэ 300.0, азарганы үнэ 125.0, бүхны үнэ 83.3, гүүний үнэ 50.0, өсвөр насны адууны үнэ 47.5, морины үнэ 35.7, ингэ шар үхрийн үнэ 33.3, өсвөр насны үхрийн үнэ 10.0, эр ба эм борлоны 4.3, эм хонины үнэ 3.4, эр ба эм төлөгний 0.9 мянган төгрөгөөр тус тус өсчээ.

Арилжаалагдаж байгаа буур, ингэ, өсвөр насны адуу, шар үхэр, үнээ, өсвөр насны үхэр, хурга, эр ба эм борлоны үнэ өмнөх оны мөн үеэс 5.6 – 24.1 хувиар өсч, бусад малын үнэ өмнөх оны мөн үеэс 1.9 – 47.2 хувиар буурчээ.


Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн:

Зөгийн бал 20000, өндөг 350, богийн сүү 800, адууны шир 20000, үхрийн шир 22500, ямааны арьс 1000, хонины ноос 1500, хужир шүү 50000, чацаргана 5000, үхрийн нүд 7000, сонгино 2500, өргөст хэмх 3500, түлээний мод 51250 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Зураг 18.1 Нас гүйцсэн бод малын үнэ, мян.төг



Зураг 18.2 Нас гүйцсэн бог малын үнэ мян.төг



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн

Зүүн бүс: Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөт бүс: Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс : Улаангом хот

Том малын зүй бусаар хорогдол: Өвчнөөр (халдвартай, халдваргүй) болон гэнэтийн аюулаар (цас, зуд, үер, ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг) хорогдсон, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) улмаас хорогдсон малыг хамруулна.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгч малын тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулж тооцно.

Төл бойжилтын хувь: Бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж тооцно.

Тариалсан талбай: Хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн хугацаанд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.




### ХИХ АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн чиглэлээр 92 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж тайлант оны эхний 7 сард оны үнээр 4.9 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж 5.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэлт 21.4 хувиар, бүтээгдэхүүний борлуулалт 14.7 хувиар өссөн байна. Нийт борлуулалтын 3.0 хувь буюу 158.6 сая төгрөгийн өлөн гэдэс боловсруулж гадаадад экспортолсон байна.


2010 оны зэрэгцүүлэх үнээр 3.2 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 33.2 хувиар буюу 808.7 сая төгрөгөөр өссөн байна. Үүний дотор боловсруулах үйлдвэрлэл 2.0 дахин, дулаан, усан хангамж түгээлт 14.5, нүүрс олборлолт 1.2 хувиар өссөн байна.

Зураг 19.1 Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зэрэгцүүлэх үнээр, сая төгрөгөөр, эхний 7 сараар



Нийт үйлдвэрлэлтийн 57.4 хувийг дулаан түгээлт усан хангамж, 32.1 хувийг боловсруулах салбарын үйлдвэрлэл, 10.5 хувийг уул уурхай олборлолт эзэлж байна.

Зураг 19.2 Аж үйлдвэрийн салбарын бүтэц




Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын тоо 708 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14.7 хувиар, 1 ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж 0.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс зэрэгцүүлэх үнээр тооцсоноор мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12 дахин, хувцас үйлдвэрлэл 5.7 дахин, усан хангамж 2.7 дахин, мах махан бүтээгдэхүүний

үйлдвэрлэл 2.7 дахин, архи ундааны үйлдвэрлэл 4.3 дахин, өлөн боловсруулалт 2.4 дахин, хүнсний бусад бүтээгдэхүүн 1.4 дахин, арьс шир гутлын үйлдвэрлэл 1.6 дахин, гурил гурилан бүтээгдэхүүн 1.2 дахин,дулаан түгээлт 7.8 хувиар, уул уурхайн олборлолт 1.2 хувиар өссөн байна.

Оны эхний 7 сард аж ахуйн нэгжүүд 44 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч, 6 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан байна. / түгээсэн цэвэр ус –180.1 мян куб м, дулаан түгээлт -4.7 мян гкал, чацарганы тос -16.7 кг, эсгий үйлдвэрлэл -1399.7 метр, болок -4.0 мян ш,гэрийн оосор бүч -2 ком/

Зураг 19.3 Аймгийн бренд бүтээгдэхүүний үйлдвэрлэл /биет хэмжээгээр, оны эхний 7 сараар



Чацарганы сиропны үйлдвэрлэл 3.8 дахин, чацарганы шүүсний үйлдвэрлэл 11.6 хувиар өсч чацарганы тосны үйлдвэрлэл 16.2 хувиар буурсан байна.

Хэрчсэн гурил 15.0 дахин, хөх шир үйлдвэрлэл 8.0 дахин, шевро үйлдвэрлэл 7.5 дахин, архины үйлдвэрлэл 7.2 дахин, дээл тэрлэг 5.7 дахин, авдар үйлдвэрлэл 4.3 дахин, хиамна үйлдвэрлэл 2.7 дахин, өлөн гэдэс үйлдвэрлэл 2.4 дахин, пальто үйлдвэрлэл 2.0 дахин, жимсний чанамал 2.7 дахин, бялуу үйлдвэрлэл 85.0, цэвэр ус үйлдвэрлэл 58.1 хувиар, бууз банш үйлдвэрлэл 53.8 хувиар, зайрмаг үйлдвэрлэл 97.4 хувиар, булигар 25.0 хувиар, нарийн боов 18.3 хувиар, гутал үйлдвэрлэл 8.7 хувиар, талх 5.7, нүүрс 1.2 хувиар тус тус өссөн байна.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ- аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.



АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2017 оны эхний 7 сард

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	хэмжих нэгж	2013 I-VII	2014 I-VII	2015 I-VII	2016 I-VII	2017 I-VII
Төрсөн хүүхдийн тоо	амьд төрөлт	1193	1246	1217	1191	1218
Нас баралт	тоо	233	257	264	285	256
1000 хүн амд ногдох нас баралт	тоо	3.1	3.5	3.5	3.5	3.15
0- 5 насны хүүхдийн эндэгдэл	тоо	25	33	28	40	25
0-1 насны хүүхдийн эндэгдэл	тоо	20	27	23	36	20
Халдварт өвчний гаралт	тоо	312	284	309	537	370
10000 хүнд ноогдох халдварт өвчин	тоо	42.0	38	41	67	45
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	тоо	183	194	222	167	188
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо,сарын эцэст	хүн	857	835	1354	1205	940
Аймгийн төсвийн орлого,оны үнээр	сая.төг	5353.6	5001.1	5126.4	5472.4	5770.7
Төсвийн зарлага,оны үнээр	сая.төг	27529.0	36611.3	30582.7	34845.1	39290.5
Төсвийн өглөг	сая.төг	693.7	230	251.1	953.0	531.7
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эхнээс	хувь	103.5	109.8	103.0	100.2	102.9
Банкны зээлийн үлдэгдэл	сая.төг	109024.9	151717.9	160915.9	160065.8	165370.1
Үүнээс: хугацаа хэтэрсэн	сая.төг	352.6	1020.3	3494	5924.2	6682.8
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл оны үнээр	сая.төг	2951.9	3450.7	3989.4	4060.8	4829.0
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр	сая.төг	2174.2	2687.9	2574.6	2432.4	3198.2
Уул уурхай олборлох үйлдвэр	сая.төг	162.9	302.6	166.0	504.0	517.6
Боловсруулах аж үйлдвэр	сая.төг	975.2	1193.5	1156.4	716.2	1481.1
дулаан түгээлт, усан хангамж	сая.төг	1036.1	1191.8	1252.2	2840.6	2830.3

## Нийгэм эдийн засгийн байдлын танилцуулга

Сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, 2017 оны эхний 7 сар

( сумдаар)

	Татварын орлого	Төсвийн орлогын ТБ	АУ-ийн бүт.үйлд, оны үнээр	үүнээс хувийн салбарынх	НДС-ийн		Гарсан гэмт хэрэг		Ажлын шинэ байранд орсон хүн	Үүнээс эмэгтэй
					орлого, сая.төг	ТБ %	бүгд	10.0 мян.хүнд ноогдох		
хэмжих нэгж	сая.төг	хувь	сая.төг	сая.төг	сая.төг	хувь	тоо	тоо	хүн	хүн
<b>ДҮН</b>	<b>5774.4</b>	<b>115.0</b>	<b>4931.5</b>	<b>4758.6</b>	<b>8750.0</b>	<b>98.0</b>	<b>188.0</b>	<b>38.3</b>	<b>316</b>	<b>154</b>
Баруунтуруун	186.9	97.8	18.7	18.7	314.7	103.0	6.0	35.1	0	0
Бөхмөрөн	194.9	135.5	0.1	0.1	151.2	93.8	1.0	7.5	4	1
Давст	63.3	113.0	7.4	7.4	129.8	103.8	4.0	41.0	0	0
Завхан	67.6	123.5	2.1	2.1	148.6	119.6	3.0	27.2	17	9
Зүүнговь	91.9	100.1	7.5	7.5	197.9	113.6	5.0	31.4	16	9
Зүүнхангай	80.1	114.2	3.9	3.9	173.4	107.3	8.0	56.5	4	1
Малчин	92.7	132.2	4.8	4.8	190.1	120.4	3.0	20.2	12	8
Наранбулаг	102.3	123.8	5.1	5.1	222.2	113.7	13.0	55.4	0	0
Өлгий	74.4	116.4	5.0	5.0	192.0	115.6	2.0	14.4	3	2
Өмнөговь	125.6	121.5	5.1	5.1	279.8	112.8	10.0	38.7	0	0
Өндөрхангай	89.1	95.8	9.8	9.8	222.7	108.4	10.0	49.8	18	14
Сагил	203.3	131.9	-	-	157.5	111.8	3.0	22.0	14	9
Тариалан	107.5	112.9	65.1	65.1	257.8	106.3	5.0	23.6	10	7
Түргэн	66.2	104.1	2.3	2.3	142.2	108.0	8.0	61.8	9	7
Тэс	130.9	105.3	109.9	109.9	299.1	105.4	16.0	52.5	12	7
Ховд	80.5	117.6	-	-	181.2	114.3	2.0	14.1	2	1
Хяргас	105.1	129.1	18.3	18.3	203.1	112.2	1.0	6.7	11	2
Цагаанхайрхан	72.1	108.2	2.3	2.3	163.0	111.1	4.0	32.6	7	1
Улаангом	3840.0	100.3	4664.1	4491.2	5123.7	91.2	84.0	43.7	177	76
<b>2016 I-VII</b>	<b>5774.6</b>	<b>104.9</b>	<b>4060.8</b>	<b>3965.2</b>	<b>8614</b>	<b>103.9</b>	<b>167</b>	<b>35.6</b>	<b>607</b>	<b>82</b>

